

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
УЛСЫН ХИМИЙН ОЛИМПИАД ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО



УЛСЫН ХИМИЙН ХХIX ОЛИМПИАД  
“ХҮСС-2008”

2008.IV.9-23

УЛААНБААТАР  
2009



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
УЛСЫН ХИМИЙН ОЛИМПИАД ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО

**УЛСЫН ХИМИЙН XVIII ОЛИМПИАД  
“ХҮНС-2008”**

2008.IV.9-23

УЛААНБААТАР  
2009

Эмхэтгэсэн:

Проф. Д.Дорж

Проф. С.Даваасүрэн

Магистр Ч.Нямгэрэл

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

Магистр Б.Сүхбаатар

Т.Баяржаргал

**УЛСЫН ХИМИЙН АРВАНЕСДҮГЭЭР  
ОЛИМПИАДЫН УРИЛГА-ХӨТӨЛБӨР**

Эрдмийн үр эх түмэнд л гэж соёолдог.

*Д.И.Менделеев*

*Аливаа хүн сурх чиглэлийг эрхэм  
болговоос хандах зүг өөрөө тогтоно.*

*Д.Сүхбаатар*

**1. Их дээд сургуулийн химийн мэргэжлийн оюутны олимпиад (МУБИС, БУС)**

**4-р сарын 9, 10**

10<sup>00</sup>-17<sup>00</sup> Оюутны олимпиадад оролцогчдыг бүртгэх. МУБИС, хичээлийн ... байр ... танхим

**4-р сарын 13**

8<sup>00</sup>-11<sup>00</sup> Оюутны А, Б бүлгийн онолын тэмцээний бодлого, тестийг хүлээн авах. Бодлого, тест сонгон боловсруулах. МУБИС, хичээлийн I байр, 115, 123-р танхим

12<sup>00</sup>-12<sup>10</sup> Улсын химийн XVIII олимпиадын оюутны тэмцээний нээлт. МУБИС, хичээлийн I байр, 116-р танхим

12<sup>10</sup>-15<sup>00</sup> Оюутны А бүлгийн онол, бодлогын тэмцээн. МУБИС, хичээлийн I байр, 116-р танхим

12<sup>10</sup>-15<sup>00</sup> Оюутны Б бүлгийн онол, бодлогын тэмцээн. МУБИС, хичээлийн I байр, 401-р танхим

**4-р сарын 14**

10<sup>00</sup>-12<sup>00</sup> Оюутны А бүлгийн сорил, туршлагын тэмцээн. МУБИС, хичээлийн Т байр, 201-р танхим

10<sup>00</sup>-12<sup>00</sup> Оюутны Б бүлгийн сорил, туршлагын тэмцээн. МУБИС, хичээлийн I байр, 115-р танхим

2. ЕБС-ийн сурагч, багш нарын олимпиад (МУИС, ХФ)

**4-р сарын 20**

10<sup>00</sup>-17<sup>00</sup> Олимпиадад оролцох 11-р ангийн сурагчид, багш нарыг бүртгэх.  
*МУИС, хичээлийн I байр 232-р танхим*

**4-р сарын 21**

10<sup>00</sup>-17<sup>00</sup> Олимпиадад оролцох 11-р ангийн сурагчид, багш нарыг бүртгэх.  
*МУИС, хичээлийн I байр 232-р танхим*

18<sup>30</sup>-19<sup>30</sup> Улсын химийн XVIII олимпиадын ажлын зөвөлгөөн. *МУИС, хичээлийн I байр, 320-р танхим*

**4-р сарын 22**

7<sup>00</sup>-10<sup>30</sup> 11-р ангийн сурагчид, багш нарын тэмцээний бодлого сонгож бэлтгэх.  
*МУИС, хичээлийн I байр, 224, 230-р танхим*

11<sup>30</sup>-15<sup>30</sup> Онол, бодлогын тэмцээн  
10-р анги. *МУИС, хичээлийн I байр, 320-р танхим*  
Багш нар. *МУИС, хичээлийн I байр, 330-р танхим*

16<sup>30</sup>-18<sup>00</sup> “Нанотехнологи” Лекц-семинар. *МУИС, хичээлийн I байр, 320-р танхим*

**4-р сарын 23**

9<sup>00</sup>-13<sup>00</sup> Сорил, туршлагын тэмцээн  
10-р анги. *МУИС, хичээлийн I байр, 330-р танхим*  
Багш нар. *МУИС, хичээлийн I байр, 224, 225, 226, 230-р танхим*

**Б. Химичдийн өдөр ”Хүнс-2008”**

17<sup>00</sup>-19<sup>00</sup> - МУИС-ийн товч танилцуулга  
- Химичдийн өдөрлөгийн нээлт  
- Нанотехнологийн үзэсгэлэн  
- Олимпиадын дүн гаргах, медаль, шагнал гардуулах  
- ХФ-ийн оюутнуудын мэндчилгээ  
- Урлагийн тогтолтууд

**УЛСЫН ХИМИЙН XVIII ОЛИМПИАДЫН ТӨВ КОМИСС**

**1. XI АНГИ****1.1. ОНОЛ БОДЛОГЫН ТЭМЦЭЭНИЙ ДААЛГАВАР****1-р зэрэглэл**

Синтезийн хийнээс метанолыг дараах урвалаар гаргадаг.





Энэ урвалын тэнцвэрийн тогтмол 500К температурт  $K_p = 6.1 \cdot 10^{-3}$  бар<sup>-2</sup>. Энэ урвалын тэнцвэр нь даралт, температур, холимгийн найрлагаас хамаарч өөрчлөгддөг.

- a). Нуурсийг халуун усны уураар шингэрүүлж синтезийн хий гарган авдаг бол урвалын тэгшитгэлийг бичнэ уу. Нуурснээс синтезийн хийг гаргах урвалын тэгшитгэлд үндэслэн синтезийн хийг ус агуулаагүй гэж үзээд 100бар даралт, 500K температурт метанолыг синтезлэхэд үүссэн холимгийн тэнцвэр тогтсон нөхцөл дэх компонентуудын молийн долийг тооцоолно уу.
- б). Синтезийн хийг ус болон метанаас гарган авах урвалын тэгшитгэлийг бичнэ уу. Метанаас синтезийн хий гаргах тэгшитгэлд үндэслэн 100бар даралт ба 500K температурын нөхцөлд метанолыг гаргахад үүссэн холимгийн компонентуудын молийн долийг тооцоолно уу.

Жич: 1бар = 100кПа

**(5 оноо)**


**Бодолт:**

$$K_P = \frac{p_{\text{CH}_3\text{OH}}}{p_{\text{CO}} \cdot p^2_{\text{H}_2}} = 6.1 \cdot 10^{-3} \text{ парциаль даралт нь: } P_i = P \cdot x_i$$

$$p_{\text{CH}_3\text{OH}} = x_{\text{CH}_3\text{OH}} \cdot P \quad p_{\text{CO}} = x_{\text{CO}} \cdot P \quad p_{\text{H}_2} = x_{\text{H}_2} \cdot P$$

$$K_P = \frac{p_{\text{CH}_3\text{OH}}}{p_{\text{CO}} \cdot p^2_{\text{H}_2}} = \frac{x_{\text{CH}_3\text{OH}} P}{x_{\text{CO}} P \cdot x^2_{\text{H}_2} P^2} = 6.1 \cdot 10^{-3} \cdot 10^4 = 61.0$$

Синтезийн хий гаргахад 1 моль CO, 1 моль H<sub>2</sub> үүссэн ба тэнцвэр тогтоход X моль CH<sub>3</sub>OH үүссэн гэвэл



$$1-x \quad 1-2x \quad x$$

Системийн нийт молийн өөрчлөлт нь: 1-x+1-2x+x=2-2x

$$\left[ K_P = \frac{x(2-2x)(2-2x)^2}{(2-2x)(1-x)(1-2x)^2} = \frac{x^4(1-x)}{(1-x)(1-2x)^2} = 61.0 \right]$$



$$244x^2 - 248 + 61 = 0$$

$$x_1 = 0.6 \text{ шийд биш} \quad x_2 = 0.42$$

Компонентуудын молийн долийг олбол:

	Моль	$x_i$
CH <sub>3</sub> OH	0.42	0.362
CO	0.58	0.5
H <sub>2</sub>	0.16	0.138
$\Sigma 1.16$		


б)



Процесс явагдсан нөхцөл өөрчлөгдөөгүй учраас  $K_p = 6 \cdot 10^{-3}$  бар<sup>-2</sup>.

Синтезийн хий гаргахад 1моль CO ба 3моль H<sub>2</sub> үүссэн байна.

Тэнцвэр тогтоход x моль CH<sub>3</sub>OH үүссэн гэвэл:



$$1-x \quad 3-2x \quad x$$

Системийн нийт молийн өөрчлөлт нь:  $1-x+3-2x+x=4-2x$

$$K_p = \frac{x(4-4x)(4-2x)^2}{(4-2x)(1-x)(3-2x)^2} = \frac{x(4-2x)^2}{(1-x)(3-2x)^2} = 61.0$$

$$248x^3 - 992x^2 + 1297x - 549 = 0$$


$$x = 0.944$$

Компонентуудын молийн долийг олбол:

	Моль	$x_i$
CH <sub>3</sub> OH	0.944	0.447
CO	0.056	0.027
H <sub>2</sub>	1.112	0.526
$\Sigma 2.112$		

## 2-р зэрэглэл

Фенол нь органик синтезд өргөн хэрэглэгддэг чухал нэгдэл юм. Тухайлбал эмийн үйлдвэрийн үндсэн түүхий эд болох X нэгдлийг дараах схемээр фенолоос гарган авдаг.




Массын 26,20%-ийн хүчилтөрөгч агуулсан У нэгдлийн исэлдэлтээр С нэгдлийг гарган авдаг. У нэгдэл хүчтэй суурьтай харилцан үйлчлэлцэж ижил моль хэмжээтэй  $Y_1$  ба  $Y_2$  үүсгэдэг. Харин сүл хүчлийн орчинд У нэгдэл нь 21,22% хүчилтөрөгч агуулсан  $Y_3$  нэгдэлд хувирдаг.  $Y_3$  нь зургаан гишүүнт дөрвөн цагирагаас тогтоно.

- a). Өмнө нь фенол гарган авах ямар аргыг хэрэглэдэг байсан бэ? Одоо хэрхэн гарган авч байгаа вэ?
- б). А, В, С, Х нэгдлүүдийг тодорхойлж, бүтцийн томьёог дүрсэлнэ үү.
- в). У,  $Y_1$ ,  $Y_2$ ,  $Y_3$  нэгдлүүдийн бүтцийн томьёог бичнэ үү.
- г). У нь  $\text{FeCl}_3$ -ийн усан уусмалтай харилцан үйлчлэлцэж нил-улаан өнгө үүсгэдэг бол урвалын тэгшитгэлийг бичнэ үү.


(6 очоо)

**Бодолт:**




- а) Өмнө нь гарган авч байсан арга:







одоо гарган авч байсан арга:




б)






(y)






(y<sub>1</sub>)




(y<sub>2</sub>)

Сул хүчлийн орчинд Y → Y<sub>3</sub> (21.22% O агуулсан)




### 3-р зэрэглэл

Катионуудыг өөр хооронд нь ялгах нь чухал процесс юм. Тухайлбал барил болон стронцийг ялгах процессыг нээрлэж болно. Эдгээр ионуудын хромат ионтой үүсгэсэн нэгдлийн уусах чанар харилцан адилгүй байдагт үндэслэн ялгаж салгадаг. Хромат ионы концентрац нь уусмалын орчин болох pH-ээс их хамаардаг бөгөөд үүнийг “хромат-бихроматын тэнцвэр” гэж нэрлэдэг.



Тэнцвэрийн тогтмол (K) нь усны молийн концентрац 55,56 моль/л үед  $1,50 \cdot 10^{15}$  бөгөөд  $\text{YY}(\text{BaCrO}_4) = 8,5 \cdot 10^{-11}$ ,  $\text{YY}(\text{SrCrO}_4) = 3,6 \cdot 10^{-5}$  болно.

Хром агуулсан ионуудын өнгө болон исэлдэн ангижрах стандарт потенциалыг дараах схемээр харууллаа.



Жич: Тоон холбогдолууд Вольтоор илэрхийлэгднэ


- Хүчтэй суурийн орчинд бари болон стронцийн хроматын уусалах чанарыг моль/л-ээр илэрхийлнэ үү.
- Ацетатын буфер ( $\text{pH}=3$ ) уусмалд 0,1 моль/л калийн бихромат агуулагдаж байсан бол хромат болон бихромат ионы концентрацийг тооцоолно уу. Энэхүү уусмал дээр маш бага хэмжээний барийн болон стронцийн ион агуулсан уусмал нэмэхэд аль тунадас эхэлж буухыг тооцоогоор батална уу.
- Ацетатын буфер уусмал бэлтгэхэд 0,10 моль/л цууны хүчлийн уусмалыг хэрэглэдэг бол  $\text{pH}=3$  бүхий буфер уусмал бэлтгэхэд хэдэн грамм натрийн ацетат хэрэгтэй вэ? Цууны хүчлийн диссоциацийн тогтмол  $K_a=1,78 \cdot 10^{-5}$  болно.
- Х ба У гэсэн стандарт потенциалыг тооцоолно уу.
- $\text{Cr(IV)}$  ион өөрөө исэлдэн ангижрах урвалд орж  $\text{Cr(III)}$  ба  $\text{Cr(VI)}$  ион үүсгэх боломжтой эсэхийг тооцоогоор батална уу.
- $\text{Cr}_2\text{O}_7^{2-}/\text{Cr}^{3+}$ -ийн электродын хагас урвалын тэгшитгэлийг бичнэ үү. 298K температурт уусмалын орчны  $\text{pH}$ -ыг 1-ээр ихэсгэхэд исэлдэн ангижрах потенциалын өөрчлөлтийг тооцоолно уу.

Жич: Нернстийн тэгшитгэл  $E = E^0 + \frac{RT}{nF} \ln \frac{[Ис]}{[Ан]}$  болно.  
(7 оноо)

### Бодолт:

a).  $S_{(\text{BaCrO}_4)} = \sqrt{YV_{(\text{BaCrO}_4)}} = \sqrt{8.5 \cdot 10^{-11}} = 9.2 \cdot 10^{-6} M$

$$S_{(\text{SrCrO}_4)} = \sqrt{YV_{(\text{SrCrO}_4)}} = \sqrt{3.6 \cdot 10^{-5}} = 6 \cdot 10^{-3} M$$



$$K = \frac{1}{1.5 \cdot 10^{15}} = 6.67 \cdot 10^{-16}$$

$\text{Cr}_2\text{O}_7^{2-}$	+	$\text{H}_2\text{O}$	$\leftrightarrow$	$2\text{H}^+$	+	$2\text{CrO}_4^{2-}$
Анх	0.1			-		-
тэнцвэрийн	0.1-x	55.56		$10^{-3}$		2x

$$K = \frac{[H^+]^2 \cdot [\text{CrO}_4^{2-}]^2}{[\text{Cr}_2\text{O}_7^{2-}][\text{H}_2\text{O}]} = \frac{10^{-6} \cdot 4x^2}{(0.1-x)55.56} = 6.67 \cdot 10^{-16}$$

$$X_1 = 3.04 \cdot 10^{-5}$$



$$[\text{Cr}_2\text{O}_7^{2-}] = 0.1 \text{M}$$

$$[\text{CrO}_4^{2-}] = 6.1 \cdot 10^{-5} \text{M}$$

$$[\text{Ba}^{2+}] = \frac{8.5 \cdot 10^{-11}}{6.1 \cdot 10^{-5}} = 1.4 \cdot 10^{-6} \text{M}$$

$$[\text{Sr}^{2+}] = \frac{3.6 \cdot 10^{-5}}{6.1 \cdot 10^{-5}} = 0.59 \text{M}$$

$\text{BaCrO}_4$  эхлэж тундасжина.



$$K_a = \frac{[\text{H}^+] \cdot [\text{CH}_3\text{COO}^-]}{[\text{CH}_3\text{COOH}]} = \frac{C_g \cdot [\text{H}^+]}{C_x}$$

$$[\text{H}^+] = \frac{K_a \cdot C_x}{C_g}$$

$$pH = pK_a + \lg \frac{C_x}{C_g} \quad pK_a = -\lg(1.78 \cdot 10^{-5}) = 4.75$$

$$x = 1.78 \cdot 10^{-3}$$


$$m_{(\text{CH}_3\text{COONa})} = 1.78 \cdot 10^{-3} \text{моль} \cdot 82 \text{г/моль} = 0.146 \text{г} = 146 \text{мг}$$

г).  $3 \cdot (-0.744) = -0.408 + 2y$

$$y = 0.912 \text{B}$$

$$0.55 + 1.34 + x - 3 \cdot (0.744) = 6 \cdot 0.293$$

$$x = 2.1 \text{B}$$



д).  $\Delta E^0 = E^0_{\text{а.н.}} + E^0_{\text{и.с.}} = 2.1 - 0.5 \cdot (1.34 + 0.55) = 1.155 \text{B}$

$\Delta G < 0$  тул Cr (IV)-ийн өөрөө исэлдэн ангижрах урвал явагдна.




$$E = E^0 + \frac{RT}{6F} \ln \frac{[\text{Cr}_2\text{O}_7^{2-}][\text{H}^{+}]^{14}}{[\text{Cr}^{3+}]^2}$$

$$E = E^0 + \frac{RT}{6F} \ln \frac{[\text{Cr}_2\text{O}_7^{2-}]}{[\text{Cr}^{3+}]^2} + \frac{RT}{6F} \underbrace{(-\ln[\text{H}^{+}]^{14})}_{14 \cdot \text{pH}}$$

$$\Delta E^0 = \frac{2.3RT14}{6F} \Delta \text{pH} = \frac{2.3 \cdot 8.31 \cdot 298 \cdot 14}{6 \cdot 96500} \cdot 1 = 0.138 \text{B}$$

## 1.2. ТЕСТИЙН ДААЛГАВАР

1. Дараах урвалын тэгшитгэл дэх исэлдүүлэгчийг ол.



- a. HAsO<sub>2</sub>      b. Sn<sup>2+</sup>      c. H<sup>+</sup>      d. Sn<sup>4+</sup>

2. Трихлорбензол (C<sub>6</sub>H<sub>3</sub>Cl<sub>3</sub>) хэдэн изомертэй байж болох вэ?

- a. 1      b. 2      c. 3      d. 4

3. Гидрид ион устай үйлчлэх үед

- a. хүчиллэг уусмал ба устөрөгч үүснэ.  
b. хүчиллэг уусмал ба хүчилтөрөгч үүснэ.  
c. шүлтлэг уусмал ба устөрөгч үүснэ.  
d. шүлтлэг уусмал ба хүчилтөрөгч үүснэ.

4. 3.01·10<sup>20</sup> тооны молекул агуулсан SF<sub>n</sub>-ийн нэгдлийн масс 54мг бол n-ийн тоог ол.

- a. 1      b. 2      c. 4      d. 6

5. Молекулдаа 5 ширхэг нүүрстөрөгчийн атом агуулсан органик нэгдлийг 7моль хүчилтөрөгчтэй шатаахад ижил молийн хэмжээтэй нүүрстөрөгчийн диоксид ба ус үссэн бол дараах функциональ бүлгүүдээс аль нь уг нэгдэлд агуулагдахгүй вэ?

- a. энгийн эфир      b. Спирт      c. Кетон      d. карбон хүчил

6. Ижил хэмжээний 0,5M NaOH-ийн уусмал руу доорх уусмалуудын алийг хийхэд уусмалын pH нь өсөх вэ?

1. H<sub>2</sub>O      2. 0.25 M Na<sub>2</sub>CO<sub>3</sub>      3. 0.5 M HCl      4. 0.6 M KOH

- a. 2, 3, 4      b. 1, 2      c. 2, 4      d. 4

7. Нэг нэгдэл агуулсан өнгөгүй шингэн усан уусмал дээр шингэрүүлсэн NaOH-ийн уусмал нэмэхэд тунадас үүсэж мөн NaOH-ийг илүүдлээр нэмэхэд тунадас уусаж байв. Мөн мөнгөний ацетатын уусмалаас нэмэхэд цагаан өнгийн тунадас үссэн бол уг нэгдэл олно уу.

- a. AlCl<sub>3</sub>      b. Ba(NO<sub>3</sub>)<sub>2</sub>      c. CuSO<sub>4</sub>      d. FeI<sub>2</sub>

8. HCN нь сул хүчил ( $K_h = 6.2 \cdot 10^{-10}$ ), NH<sub>3</sub> нь сул суурь ( $K_c = 1.8 \cdot 10^{-5}$ ). NH<sub>4</sub>CN –ийн 1,0 M-ийн уусмалын орчинг олно уу.

- a. саармаг      b. сул хүчиллэг      c. сул суурилаг      d. хүчтэй суурилаг

9. H<sub>2</sub>NCH<sub>2</sub>CH<sub>2</sub>COOH томьёотой нэгдэл нь. . . . . болно.

- a. амид      b. амин хүчил      c. тосны хүчил      d. нуклейн хүчил

10. 20,0гр C<sub>6</sub>H<sub>10</sub>-г илүүдэл хэмжээний хлороор үйлчилж 18,3гр C<sub>6</sub>H<sub>10</sub>Cl<sub>2</sub> (1,2 дихлорциклогексен) гарган авсан бол урвалын гарцыг тодорхойл.


- a. 45,8%      b. 49.0%      c. 53.7%      d. 64.0 %

11. Дизель хөдөлгүүрээс гарч буй хий нь CO<sub>2</sub> ба H<sub>2</sub>O-ийн холимог байх бөгөөд уг холимгийг 447К-д битүү саванд хураан авсан. Температурыг 298K болтол бууруулахад даралт нь 3,0 атм-с 0,80 атм болтол буурчээ. Холимог дахь CO<sub>2</sub> ба H<sub>2</sub>O-ийн молийн харьцааг олно уу.

- a. 2:3      b. 1:1      c. 2:5      d. 1:4

12. 20.0мл Ba(OH)<sub>2</sub>-ийн усмалыг 0,245M HCl-ийн усмалаар титрлэхэд 27,15 мл зарцуулагдсан бол Ba(OH)<sub>2</sub>-ийн усмалын молийн концентрацийг ол.  
 a. 0,166 M      b. 0,180 M      c. 0,333 M      d. 0,666 M

13. 2N<sub>2</sub>(хий)+6H<sub>2</sub>O(хий) = 3O<sub>2</sub>(хий)+4NH<sub>3</sub>(хий) гэсэн урвалын энтальпийн өөрчлөлтийг дараах термохимиин урвалын тэгшитгэлүүдийг ашиглан тооц.



- a. -576 кЖ/моль    b. -392 кЖ/моль    c. 392 кЖ/моль    d. 1268 кЖ/моль

14. Дараах нэгдлүүдийн аль нь усанд хамгийн муу уусах вэ?

- a. CH<sub>3</sub>COOH    b. CH<sub>3</sub>COONa    c. CH<sub>3</sub>CH<sub>2</sub>NH<sub>2</sub>    d. CH<sub>3</sub>-O-CH<sub>3</sub>

15. 0.025M KOH-ийн усмалын pH хэд байх вэ?


- a. 12.40    b. 10.31    c. 7.0    d. 9.2

16. Металл цайрыг магний нитратын ба мөнгөний нитратын агуулсан усмалд хийхэд ямар урвал явагдах вэ?

- |                              |                               |
|------------------------------|-------------------------------|
| 1. Цайр исэлдэнэ             | 2. Mg <sup>2+</sup> ангижрана |
| 3. Ag <sup>+</sup> ангижрана | 4. Ямар ч урвал явагдахгүй    |
| a. 1, 2                      | b. 1, 3                       |
| c. 2                         | d. 4                          |

17. CH<sub>3</sub>OH, CH<sub>2</sub>O ба CHO<sub>2</sub><sup>-</sup> нэгдлүүд дэх C—O холбооны уртыг харьцуулна уу.

- |   |   |
|---|---|
| a. CH <sub>3</sub> OH < CH <sub>2</sub> O < CHO <sub>2</sub> <sup>-</sup> | b. CH <sub>2</sub> O < CH <sub>3</sub> OH < CHO <sub>2</sub> <sup>-</sup> |
| c. CHO <sub>2</sub> <sup>-</sup> < CH <sub>3</sub> OH < CH <sub>2</sub> O | d. CH <sub>2</sub> O < CHO <sub>2</sub> <sup>-</sup> < CH <sub>3</sub> OH |



Дээрх урвалаар хамгийн хурдан үүсэх завсрлын бүтээгдэхүүнийг заана уу.

- |   |  |
|---|--|
| a. $\begin{array}{c} \bullet \\   \\ \text{CH}_2\text{CHCH}_2\text{CH}_2\text{CH}_3 \end{array}$        | b. $\begin{array}{c} \text{CH}_3 \\   \\ \bullet \text{CH}_2\text{CH}_2\text{CH}_2\text{CH}_3 \end{array}$ |
| c. $\begin{array}{c} \text{CH}_3 \\   \\ \text{CH}_3\text{CH}\bullet\text{CH}_2\text{CH}_3 \end{array}$ | d. $\begin{array}{c} \text{CH}_3 \\   \\ \text{CH}_3\text{CH}_2\text{CH}\bullet\text{CH}_3 \end{array}$    |

19. CuSO<sub>4</sub>-ийн усмалд 20 минутын турш 2 ампер гүйдлээр электролиз явуулахад хэдэн грамм зэс ялгарах вэ?

- a. 0.20г    b. 0.40г    c. 0.79г    d. 1.6г

20. Хоёрдогч спиртийн сул исэлдэлтээр ямар органик нэгдэл үүсэх вэ?

- a. хүчил    b. альдегид    c. эфир    d. кетон

21. Тосны хүчил нь дараах нэгдлүүдийн алантай нь урвалд орж өөх тос үүсгэх вэ?

- a. холестерин    b. Глюкоз    c. глицерин    d. фенол


22. Дараах карбон хүчлүүдийн аль нь хамгийн хүчиллэг чанартай вэ?

- a. CH<sub>3</sub>COOH    b. HCOOH    c. C<sub>6</sub>H<sub>5</sub>COOH    d. Cl<sub>3</sub>CCOOH

23. (CH<sub>3</sub>)<sub>3</sub>COCH<sub>3</sub>-ийг гарган авах хамгийн хялбар аргыг сонгоно уу.





- |   |   |
|---|---|
| a. NaOCH <sub>3</sub> +(CH <sub>3</sub> ) <sub>3</sub> CCl→ | b. (CH <sub>3</sub> ) <sub>3</sub> COH+CH <sub>3</sub> J→ |
| c. (CH <sub>3</sub> ) <sub>3</sub> CH+CH <sub>3</sub> OH→   | d. (CH <sub>3</sub> ) <sub>3</sub> COK+CH <sub>3</sub> J→ |

24. Дараах нэгдлүүдийн аль нь устай хамгийн хурдан харилцан үйлчлэлцэх вэ?







25. Дараах хялбар томьёонуудаас аль нь хамгийн олон изомертэй вэ?  
 a.  $\text{C}_4\text{H}_9\text{Cl}$       b.  $\text{C}_7\text{H}_{16}$       c.  $\text{C}_6\text{H}_6$       d.  $\text{C}_3\text{H}_7\text{Br}$

26. Дараах спиртүүдийн аль нь хамгийн хялбар исэлдэх вэ?



27. Дараах нэгдлүүдээс хамгийн хүчтэй хүчлийг заана уу



28. Нонатетраен-1,3,5,7-д хичнээн ширхэг цис ба транс изомерууд байх вэ?



a. 8

b. 5

c. 4

d. 2

29.  $\text{C}_6\text{H}_4\text{O}$  найрлагатай дараах нэгдлүүдийн аль нь  $25^{\circ}\text{C}$ -д хамгийн их ханасан уурын даралттай байх вэ?



30.  $\alpha$ -линолейны хүчлийн хоёрчийн холбооны тоог тодорхойлохын тулд 0,342гр иодыг 0,125гр хүчилтэй харилцан үйлчлэлцжээ.  $\alpha$ -линолейны хүчлийн молекул масс 278,4г/моль бол хоёрчийн холбооны тоог ол.

a. 1

b. 2

c. 3

d. 4

### 1.3. СОРИЛ ТУРШЛАГЫН ДААЛГАВАР

Хувилбар 1

#### Калийн оксалатоферрат (III) комплексийг гарган авч томьёог тодорхойлох

Энэ туршлагаар анионы комплекс Калийн оксалатоферрат (III)-ыг гарган авна. Энэ комплекс нь ногоон өнгийн талст бөгөөд халуун усанд сайн, хүйтэн усанд муу уусдаг, гэрэлд мэдрэмтгий.

##### Сорил 1. Комплексийг гарган авах

Танд хуруу шилэнд 1,35 г калийн оксалатын моногидратыг ( $K_2C_2O_4 \cdot H_2O$ ) жигнэж тавьсан байгаа. 4,5 мл нэрмэл ус нэмээд давсыг уустал спиртэн дэн дээр халааж өгнө (Буцалгаж болохгүй!). Өөр нэг хуруу шилэнд төмөр(III)-ийн хлоридын уусмалаас 2 мл-ыг таслан авч мөстэй стаканд хөргөнө. Энэ төмрийн хлоридын хүйтэн уусмалыг калийн оксалатын халуун уусмал руу нэмж шилэн савхаар хутгана. Бүтээгдэхүүнээ талсжуулахын тулд мөстэй стаканд хөргөнө. Талстыг шүүж аваад мөстэй стаканд хөргөсөн 2 мл орчим цэв хүйтэн усаар угаана. Шүүгдэс юулүүрээс дусахаа больсны дараа комплексоо алдагдалгүйгээр уусмалд шилжүүлэхийн тулд комплекстэй шүүлтүүрийн цаасыг юулүүрээс салгалгүйгээр халуун ус (усаа хуруу шилэнд спиртэн дэн дээр халаагаарай) нэмж уусган үүссэн уусмалыг 100 мл-ийн хэмжээст колбонд бүрэн шилжүүлэн хэмжээс хүртэл усаар шингэлнэ.

##### Сорил 2. Комплекс дахь оксалат ионы агуулгыг тодорхойлох

Өмнөх даалгаварт бэлтгэсэн уусмалаас 5 мл-ыг шувтан колбонд авч хүхрийн хүчлийн 1 н-ийн уусмалаас 20 мл-ийг нэмж  $70-80^{\circ}C$  хүртэл плиткэн дээр халаана. Калийн перманганатын 0.05 н-ийн уусмалаар халуун уусмалаа титрлэж комплексийн оксалатын агуулгыг тогтооно. Титрлэсэн дээжээ хаялгүйгээр төмөр тодорхойлоход хадгална.

Жич:  $70-80^{\circ}C$  гэдэг нь нүцгэн гараар колбыг барьж болохгүй гэсэн үг юм.

##### Сорил 3. Комплекс дахь төмөр (III) ионы агуулгыг тодорхойлох

Оксалат ионы агуулгыг тодорхойлсон дээжээ 3-5 мин буцалгаж хөргөөд 20 мл усаар шингэлнэ. 5-сульфосалицилын хүчлийн уусмалыг индикатор болгон хэрэглэн Трилон Б-гийн 0.05 н-ийн уусмалаар өнгө нь улаан ягаанаас шар болтол нь титрлэнэ. Титрлэлтийн эцсийн цэгийг нарийн тогтоохын тулд өнгө нь хувирсны дараа нэг дусал индикатор нэмж дахин нэг дусал Трилон Б -гийн уусмал нэмнэ.

Ийнхүү индикатор болон Трилон Б -гийн уусмалаас ээлжлэн дусал дуслаар нэмэн өнгө хувирахаа болитол титрлэнэ.

### Даалгавар

1. Комплекс дахь оксалат ионы агуулгыг тодорхойлоход явах урвалын тэгшитгэлийг бичиж электрон ионы аргаар тэнцүүлнэ үү.
2. Комплекс дахь оксалат ионы агуулгыг тооцоолсон дүнгээ хүснэгтэнд бичнэ үү.
3. Комплекс дахь төмөр (III) ионы агуулгыг тодорхойлоход явагдсан өнгө хувирах урвалын тэгшитгэлийг бичнэ үү.
4. Комплекс дахь төмөр (III) ионы агуулгыг тооцоолсон дүнгээ хүснэгтэнд бичнэ үү.
5. Оксалат болон төмөр (III) ионы агуулгыг тооцоолсон дүнгээ үндэслэн комплексийн томъёог тогтооно уу.

### Сорилын гүйцэтгэлийг бөглөх хүснэгт

1. Комплекс дахь оксалат ионы агуулгыг тодорхойлоход явах урвалын тэгшитгэлийг бичиж электрон ионы аргаар тэнцүүлнэ үү.
2. Комплекс дахь оксалат ионы агуулгыг тооцоолсон дүн:

Титрлэлт	Комплексийн уусмалын эзэлхүүн, мл	Зарцуулагдсан KMnO <sub>4</sub> -ын уусмалын эзэлхүүн, мл
1-р титрлэлт		
2-р титрлэлт		
Дундаж		
Комплекс дэх оксалатын массын агуулга: _____ г		

3. Комплекс дахь төмөр (III) ионы агуулгыг тодорхойлоход явагдсан өнгө хувирах урвалын тэгшитгэл:

4. Комплекс дахь төмөр (III) ионы агуулгыг тооцоолсон дүн:

Титрлэлт	Комплексийн уусмалын эзэлхүүн, мл	Зарцуулагдсан Трилон Б –гийн уусмалын эзэлхүүн, мл
1-р титрлэлт		
2-р титрлэлт		
Дундаж		
Комплекс дэх тэмрийн массын агуулга:		_____ г

5. Комплексийн томъёо:

--

**1.4. УЛСЫН ХИМИЙН XIX ОЛИМПИАДЫН XI АНГИЙН  
СУРАГЧДЫН ТЭМЦЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

№	Сурагчийн овог, нэр	Аймаг, хот, Сургууль	Оноо					Байр
			Тест	Бодлого			Сорил	
1	2	3						
1	Д. Уянга	УБ, Шинэ Монгол	4,4	2,2	2,5	1,3	7,6	18,00
2	Д. Номуунтуул	УБ, Мон-Турк	4,2	2,6	0,75	3,1	5,85	16,50
3	Б. Ихжаргалан	УБ, Шинэ Монгол	4	0,95	4,5	2,2	4,15	15,80
4	Д. Ганжигүүр	УБ, Мон-Турк	4	1,9	1,75	4,2	3,75	15,60
5	Л. Ганчимэг	Орхон	5	2,4	0,875	3,7	3,25	15,225
6	Э. Төрбат	УБ, Мон-Турк	4	1,5	0,75	2,4	5,3	13,95
7	Г. Наранцацрал	УБ, Шинэ Монгол	3,2	1	1,25	1,5	6,65	13,60
8	М. Цацрал	Дархан-Уул	3,4	2	1,5	0,8	4,9	12,60
9	Б. Халиунаа	УБ, Шинэ Монгол	3,6	0,8	0,5	1,5	3,8	10,20
10	Д. Толхынжан	Баян-Өлгий	2,6	0,8	0,25	0	6,45	10,10
11	Б. Хандмаа	УБ, 21-р сур	3,2	1,2	0,25	2,3	2,4	9,35
12	Б. Энхгэрэл	УБ, 21-р сур	4,2	0,8	0,25	0,5	3,55	9,30
13	Б. Намсаманд	Сэлэнгэ	2,4	0,5	1	1	4,3	9,20
14	Б. Мөнх-Од	УБ, Шинэ Монгол	3,8	0,6	0,5	0	4,1	9,00
15	Ц. Болортуул	Дорнод	2,2	0,5	0,25	2,7	3	8,65
16	Б.Бадамсэрээжид	Ховд	3,2	0,8	0,75	0,9	2,6	8,25
17	П. Баярцэцэг	Завхан	4	0,9	0,25	0	2,95	8,10
18	Н. Наранзул	Увс	3,6	0	0,25	1,1	3	7,95
19	М. Мөнхдэлгэр	УБ, 6-р сур	3,4	0,4	0,75	0,5	2,75	7,80
20	Ж. Цэрэнханд	УБ, Мон-Турк	2,2	0,8	0	0,5	3,3	6,80
21	Б. Ганцэцэг	Хөвсгөл	3,4	0,6	0,75	0	2	6,75
22	Б. Ундраа	Дорноговь	2	0,4	0,25	0	2,6	5,25
23	М. Одбаатар	Баянхонгор	2	0,8	0,25	0	2,1	5,15
24	Б. Бум-Аюуш	Өвөрхангай	2,6	0,8	0,25	0	1,4	5,05
25	Л. Уранчимэг	Булган	2,6	0,6	0,25	0	1,4	4,85
26	Э. Оюун	Сүхбаатар	2,2	0,4	0,25	0	2	4,85
27	Д. Энх-Амгалан	Говьсүмбэр	2,4	0	0,25	0	1,8	4,45
28	Б. Ганбат	Архангай	2,4	0	0,5	0	1,2	4,10
29	Б. Гансүх	Дундговь	1,8	0,8	0	0	1,3	3,90
30	Г. Энхдэлгэр	Говь-Алтай	2	0,4	0,25	0	1,1	3,75
31	Ш. Цэцэгбаяр	Төв аймаг	1,8	0,4	0,25	0	1,3	3,75
32	Г. Гэрэлтуяа	Хэнтий	1	0,4	0,25	0	1,9	3,55

## 2. БАГШ НАР

### 2.1. ОНОЛ БОДЛОГЫН ТЭМЦЭЭНИЙ ДААЛГАВАР

#### 1-р зэрэглэл

$^{131}\text{I}$  нь иодын цацраг идвэхт изотоп бөгөөд анагаах ухаанд янз бүрийн өвчнийг оношлоход хэрэглэгддэг. Энэхүү изотоп нь  $\beta$  задралтай ба задрах урвалын хурдны тогтмол нь  $9,93 \cdot 10^{-7} \text{с}^{-1}$  болно.

#### Даалгавар

1.  $^{131}\text{I}$ -ын задрах урвалын тэгшигтгэлийг бичиж тэнцүүлнэ үү.
2.  $^{131}\text{I}$ -ын хагас задралын үеийг олж, өдрөөр илэрхийлнэ үү.
3.  $^{131}\text{I}$ -ын идэвх анхны идэвхийнхээ 30% болтлоо багасахад шаардагдах хугацааг олно уу.
4. Гейгерийн тоолуур нь  $10^{-4}$  мкКю –гийн эрэмбийн идэвхийг тодорхойлж чаддаг. Тэгвэл тоолуурын мэдэрч чадах  $^{131}\text{I}$  –ын хамгийн бага идэвхийг тооцоолно уу. 1 Кю нь секундэд  $3,7 \cdot 10^{-7}$  задрал хийж байгаа идэвхт изотопын хэмжээ юм.

(5 оноо)

#### 2-р зэрэглэл

Хүхэр нь хүчилтөрөгч болон галогенуудтай олон янзын нэгдлийг үүсгэдэг. Тэдгээр нэгдлүүд нь ихэнхдээ молекул бүтэцтэй байх бөгөөд усаар хялбархан задардаг.

#### Даалгавар

1.  $\text{SCl}_2, \text{SO}_2, \text{SO}_2\text{ClF}, \text{SF}_4, \text{SBrF}_3$  нэгдлүүдийн бүтцийн томьёог бичнэ үү. Ингэхдээ холбоонд оролцоогүй бүх электронуудыг үзүүлээрэй.

Молекулдаа хүхрийн нэг атом ба хүчилтөрөгч, галоген агуулсан А нэгдлийг судалжээ. Эхлээд чанарын шинжилгээ гүйцэтгэжээ. Үүний тулд А бодисоос бага зэргийг авч устай урвалд оруулав. Энэ үед ямар нэгэн исэлдэн ангижрах урвал явагдаагүй бөгөөд урвалын бүтээгдэхүүнүүд усанд бүрэн уусчээ. Уусмалыг азотын хүчлээр хүчиллэгжүүлээд мөнгөний нитратаар үйлчлэхэд шаравтар өнгийн тунадас буув. Хоёр дахь туршилтаар калийн перманганатын хүчиллэг уусмалын өнгийг арилгасан бөгөөд барийн нитрат нэмэхэд цагаан тунадас буужээ. Чанарын шинжилгээний дараа А бодисоос 7,9 граммыг жигнэн аваад 250мл уусмал бэлтгэжээ. Энэ уусмалаас 25мл-ийг таслан аваад азотын хүчил ба илүүдэл хэмжээгээр мөнгөний нитратын уусмал нэмээд буусан тунадсыг хатаагаад жинлэхэд 1,452г масстай байв.

2. Анхны А бодисын томьёог олно уу.
3. А бодисын усанд уусах үед явагдах урвалын тэгшигтгэлийг тэгшигтгэлийг бичнэ үү. Хэрвээ А бодисоо олоогүй бол  $\text{SOCIF}$  нэгдлийг ашиглаарай.

(6 оноо)

### **3-р зэрэглэл**

Х полимер нь 88,25% С ба 11,75% Н агуулдаг. Түүний шингэрүүлсэн уусмал нь бром болон озонтой харилцан үйлчлэлцдэг. Х полимерын дулааны задралаар дэгдэмхий шингэн Y 58%-ын гарцтайгаар үүсдэг. Y нэгдэл нь 34°C температурт буцалж эхлэх ба 88,24% С ба 11,75% Н агуулна. X –полимерийн крекинг задрал ба Y нэгдлийн Дильс-Алдерын цагригжих урвалуудаас нь өндөр температурт буцалдаг бүтээгдэхүүнүүд үүснэ. Y нэгдлийн уурын устөрөгчтэй харьцуулсан нягт нь 34 болно. Y нэгдлийн бромжих урвалаар 82,5% бром агуулсан нэгдэл үүсдэг байна. Y нэгдлийг озонжуулсны дараа зөвлөн ангижруулахад A ба B бодисууд 2:1 молийн харьцаатайгаар үүсэх бөгөөд зөвхөн В нь л иodoформтой эерэг урвал өгдөг.

#### **Даалгавар**

1. Y, A, B нэгдлүүдийн молекул массыг олно уу.

2. Y нэгдлийн бромжих урвалын тэгшитгэлийг бичиж тэнцүүлнэ үү.

Катализаторын оролцоотойгоор устөрөгчжүүлэхэд 13,6г X нэгдэл нь 0,2 моль устөрөгчийг шингээдэг. X нэгдлийг озонжуулаад, зөвлөн ангижруулахад Z(60% С,8% Н) нэгдэл үүснэ.

3. Z нэгдлийнмолекул томьёог олно уу.

Z нэгдэл нь фелингийн уусмалд эерэг урвал өгдөг. Z нэдлийг зөвлөн исэлдүүлж С хүчлийг гаргаж аваад KOH –ын усан уусмалаар титрлэв. 0,116г С бодис нь 0,001 моль KOH- ыг саармагжуулдаг. 2,90гр С нэгдэл 9,85гр иodoформтой урвалд ордог. Мөн дээрх шүлтлэг шүүгдсийг хүчиллэгжүүлэхэд E нэгдэл үүсдэг.

4. С бодисын молекул масс ба Z нэгдэл дэх функциональ бүлгүүдийг олно уу. Е бодисыг халаахад усаа алдаж F үүсгэдэг бөгөөд E ба F нь хоёулаа илүүдэл хэмжээний этанолын хүчиллэг уусмалтай харилцан үйлчилж G( $C_8H_{14}O_4$ ) нэгдлийг үүсгэнэ.

5. C, E, F, Z нэдлүүдийн бүтцийн томьёо болон E→F→G схемийн дагуу явагдах урвалын тэгшитгэлүүдийг бичнэ үү.

**(7 оноо)**

## 2.2. ТЕСТИЙН ДААЛГАВАР

1. Талст гидрат дахь усыг халаах замаар тодорхойлох туршилт явуулжээ. Дараах хариултуудаас аль нь усыг бүрэн ууршсныг батлах вэ?
 

А. Талст хайлах	Б.Талст өнгөө хувиргах
В.Масс нь буурах	Г.Усны уур ажиглагдахаа болих
Д.Дараалсан хоёр хэмжилтийн масс тэнцүү байх	
2. Аль анион нь исэлдэх ба ангижрах урвалд хоёуланд орж чадах вэ?
 

А. $\text{MnO}_2^-$	Б. $\text{CO}_3^{2-}$	В. $\text{K}^+$	Г. $\text{OCl}^-$	Д. $\text{S}^{2-}$
---------------------	-----------------------	-----------------	-------------------	--------------------
3. Нэгэн нэгдэлд нүүрстөрөгч массын 57,48%, устөрөгч 4,22%,хүчилтөрөгч 38,29% тус тус эзэлдэг бол хялбар томьёог нь заана уу.
 

А. $\text{C}_2\text{H}_2\text{O}$	Б. $\text{C}_4\text{H}_3\text{O}_2$	В. $\text{C}_5\text{H}_4\text{O}_2$	Г. $\text{C}_6\text{H}_6\text{O}_3$	Д. $\text{C}_8\text{H}_7\text{O}_4$
-----------------------------------	-------------------------------------	-------------------------------------	-------------------------------------	-------------------------------------
4.  $\text{NaOH}$ -ийн 30%-ийн уусмалын нягт нь 1,33г/мл бол молийн концентрацийг олно уу.
 

А.8,25M	Б.9,98M	В.16M	Г.24M
---------	---------	-------	-------
5. Дараах тэгшитгэлд хурдыг моль/л·с нэгжээр илэрхийлдэг бол хурдны тогтмол нь ямар нэгжтэй вэ?
 
$$\square = K[A][B]^2$$

А.моль·л <sup>-2</sup> ·с <sup>-2</sup>	Б.моль·л <sup>-1</sup> ·с <sup>-1</sup>	В.л <sup>2</sup> ·моль <sup>-1</sup> ·с <sup>-1</sup>	Г.л <sup>3</sup> ·моль <sup>-3</sup> ·с <sup>-2</sup>	Д.моль·л·с
---	---	---	---	------------
6. Метиламины 0,25M концентрацтai уусмал дахь устөрөгч ионы концентрацийг олно уу. Метиламины диссоциацийн тогтмол нь  $K=4,4 \cdot 10^{-4}$ 

А.1,1·10 <sup>-4</sup>	Б.1·10 <sup>-2</sup>	В.9,1·10 <sup>-11</sup>	Г.9,5·10 <sup>-13</sup>	Д.2·10 <sup>-6</sup>
------------------------	----------------------	-------------------------	-------------------------	----------------------
7. Нэг суурьтай сул хүчлийн 0,01M концентрацтai уусмалын нийт жижиг хэсгийн 0,4% нь иончлогддог бол диссоциацийн тогтмолыг ол.
 

А.1,6·10 <sup>-10</sup>	Б.1,6·10 <sup>-7</sup>	В.4·10 <sup>-5</sup>	Г.4·10 <sup>-3</sup>	Д.2·10 <sup>-4</sup>
-------------------------	------------------------	----------------------	----------------------	----------------------
8.  $\text{Cl}_2 + \text{OH}^- \rightleftharpoons \text{Cl}^- + \text{ClO}_3^-$  тэгштгэлийг тэнцүүлэх үед  $\text{OH}^-$  ионы өмнө бичих коэффициенийг олно уу.
 

А.1	Б.2	В.3	Г.4	Д.6
-----	-----	-----	-----	-----
9. 500мл эзэлхүүнтэй, 1,0M концентрацтai никел / $\text{Ni}^{2+}$ / -ийн давсны уусмал дундуур 2A хүчтэй гүйдлийг 3 цагийн турш нэвтрүүлжээ. Электролизын дараах уусмалын концентрацийг олно уу.
 

А.0,39M	Б.0,46M	В.0,58M	Г.0,78M	Д.0,89M
---------	---------	---------	---------	---------
10. 4f давхрааны өмнө ямар орбиталь бөглөгддөг вэ?
 

А.6s	Б.5p	В.5d	Г.3f	Д.4d
------	------	------	------	------
11. Дараах квантын дөрвөн тооны цогцоос аль нь боломжтой вэ?
 

А.1,0,0,-1/2	Б.1,1,0,+1/2	В.2,1,2+1	Г.3,2-2,0	Д.4,0-1,-1/2
--------------	--------------	-----------	-----------	--------------
12. Элементүүдийг иончлолын энергийн өсөх дараалаар байрлуулсан бол аль тохиолдол нь зөв бэ?
 

А.Li, B, Be	Б.Li, Be, B	В.B, Be, Li	Г.B, Li, Be	Д.Be, B, Li
-------------	-------------	-------------	-------------	-------------
13.  $\text{S}_2\text{O}_8^{2-}$ ион хичээн валентын электрон вэ?
 

А.58	Б.60	В.62	Г.64	Д.66
------	------	------	------	------
14. Аль жижиг хэсгийнх нь хувьд холбооны энерги хамгийн ихтэй байх вэ?
 

А.NO	Б. $\text{O}_2^-$	В. $\text{NO}^-$	Г. $\text{O}_2$	Д. $\text{O}_2^-$
------	-------------------	------------------	-----------------	-------------------
15. Пронпаны бүрэн шаталтаар нүүрстөрөгчийн атомын эрлийзжилт хэрхэн өөрчлөгдхөх вэ?
 

